МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр Дугаар А/273 Мөрөн сум

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.4, 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар санал, санаачилга гаргаж, тэдний аж байдлыг сайжруулах чиглэлээр үр дүнтэй хамтран ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулж, гишүүдийг мэдээлэл, арга зүйгээр хангаж, зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг “Хөвсгөл аймгийн Залуучуудын хөгжлийн төв” (ОНӨААТҮГ)-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ө.Ууганцэнгэл)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

671 010839

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын
27-ны өдрийн А/273 дугаар захирамжийн хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
АЙМГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга
- Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга
- Иргэний нийгмийн байгууллага (Залуучуудын төлөөлөл-1)

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

- Хөвсгөл аймгийн Залуучуудын хөгжлийн төв (ОНӨААТҮГ)-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

_____oOo_____